



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 12 дугаар сарын 27
№ 48 /957/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

2329

**Гаалийн тариф, гаалийн
татварын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын
хууль

2331

**Боловсролын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай**

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

2333

**Бүтэц, зохион байгуулалтын
зардлын талаар авах зарим арга
хэмжээний тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

819.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		2329
820.	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		2331
821.	Дээд боловсролын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай		2332
822.	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2332

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

823.	Монгол Улсын Их Хурлын 2012 оны 50 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 78	2332
824.	Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 79	2333

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

825.	Бүтэц, зохион байгуулалтын зардлын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 142	2333
826.	Тусгай зориулалтаар 2017 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай	Дугаар 155	2334
827.	Оюутны спортын IV их наадам зохион байгуулах тухай	Дугаар 158	2336

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:



1/4 дүгээр зүйлийн 4.11 дэх хэсэг:

“4.11.Хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтад орсон боловч энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7.2, 31.7.3-т заасан нотлох баримт бичиггүй бараанд энэ хуулийн 31.7.1-д заасныг үндэслэн нэн тааламжтай тариф хэрэглэнэ.”

2/31 дүгээр зүйлийн 31.7 дахь хэсэг:

“31.7.Барааны гарал үүслийг нотлох баримт бичиг нь дараахь хэлбэртэй байна:

31.7.1.барааны гарал үүслийн мэдүүлэг буюу үйлдвэрлэгч, худалдагч, экспортлогчоос барааны гарал үүслийн талаар тусгасан мэдээлэл бүхий үнийн нэхэмжлэх, тээврийн баримт бичиг;

31.7.2.барааны гарал үүслийг баталгаажуулсан мэдүүлэг буюу тухайн улсын эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан гарал үүслийн мэдүүлэг;

31.7.3.барааны гарал үүслийн гэрчилгээ буюу барааны гарал үүслийг гэрчилж, тухайн улсын эрх бүхий байгууллагаас тусгай маягтаар баталгаажуулан олгосон гэрчилгээ.”

3/31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсэг:

“31.8.Гарал үүслийн гэрчилгээ заавал шаардагдах барааны жагсаалтыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн гарчгийн “баримт” гэсний дараа “бичиг” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/4 дүгээр зүйлийн 4.5-4.7 дахь хэсэг:

“4.5.Нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтыг Засгийн газар батлах бөгөөд уг жагсаалтад хамаарах улсын гарал үүсэлтэй бараа нь гарал үүслийг нотлох баримт бичигтэй байна.

4.6.Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад ороогүй улсын гарал үүсэлтэй бараанд ердийн тариф хэрэглэнэ.

4.7.Энэ хуулийн 4.5-д заасан барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулахыг гаалийн байгууллага зөвшөөрсөн өдрөөс хойш уг барааны



гарал үүслийг нотлох баримт бичгийг 45 хоногийн дотор нөхөн гаргаж өгсөн бол хөнгөлөлттэй тариф хэрэглэх бөгөөд энэ тохиолдолд илүү төлсөн татварыг гаалийн байгууллага холбогдох хууль тогтоомжид заасны дагуу буцаан олгоно.

2/31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг:

“31.3.Нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тарифт хамрагдахын тулд мэдүүлэгч нь барааны гарал үүслийг нотлох баримт бичгийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.”

4 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 34 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.5 дахь хэсэг нэмсүгэй:

“36.5.Удирдах зөвлөлийн гишүүнийг гурван жилийн хугацаагаар сонгох буюу томилно. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгийг жил бүр өөрчилж болно.”

2 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалтын “судалгаа, арга зүйн байгууллага,” гэсний дараа “төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллеж,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалтын “олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль” гэсний өмнөх “төрийн өмчит” гэснийг “төрийн өмчийн” гэж, 36 дугаар зүйлийн 36.5-36.11 дэх хэсгийн дугаарыг “36.6-36.12” гэж, 36.11 дэх хэсгийн 36.11.1-36.11.6 дахь заалтын дугаарыг “36.12.1-36.12.6” гэж, 36.12 дахь хэсгийн дугаарыг “36.13” гэж, 36.13 дахь хэсгийн дугаарыг “36.15” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ЗҮЙЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Дээд боловсролын тухай хуулийн 11¹, 11² дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “нэг удаа” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 78

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын 2012 оны
50 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн, мөн хэсгийн 3 дахь заалтын “Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын” гэснийг “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж, мөн хэсгийн 2 дахь заалтын “Хууль зүйн” гэснийг “Хууль зүй, дотоод хэргийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар
хот

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар
хот

Бүтэц, зохион байгуулалтын зардлын талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 47.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэрээр төсвийн зарим байгууллагад хийсэн бүтцийн өөрчлөлттэй холбогдож гарсан төсөвт урьдчилан тусгах боломжгүй зардалтай холбоотой дараах асуудлыг 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрөөр тасалбар болгон эцэслэн шийдвэрлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:

1.1. цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өр төлбөрийг барагдуулах;

1.2. байгууллагыг татан буулгаж, чиг үүргийг нь орон тооны хамт цомхотгосны улмаас ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал;

1.3. бүтцийн өөрчлөлттэй холбоотой шийдвэрийг зохион байгуулах үүрэг бүхий комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааны төсөвт тусгагдаагүй нэмэлт зардал, татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсан байгууллагын архив, эд хогшлыг нүүлгэн шилжүүлэхэд гарсан бусад зардал.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан зардалд шаардагдах хөрөнгө тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөвт тусгагдаагүй тохиолдолд нэмж шаардагдах хөрөнгийг 2016 оны улсын төсвийн бүтцийн өөрчлөлтийн зардлаас санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1, 2 дугаар зүйлд заасан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хуульд заасны дагуу тайлагнахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

САНГИЙН САЙД

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар
хот

**Тусгай зориулалтаар 2017 онд агнах, барих
агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай**

Амьтны тухай хуулийн 26.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Тусгай зориулалтаар 2017 онд угалз 68, тэх 75, халиун буга 32, бор гөрөөс 10, зэрлэг гахай 10, цагаан зээр 100, агнуурын шувуу 400 хүртэл



толгойг агнуулахаар, тул загас 500 толгойг барьж буцаан тавиулахаар тус тус тогтоосугай.

2. Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хэмжээ”-ний хүснэгтийн дээд талд “ам.доллараар” гэснийг ”тооцооны нэгж” гэж, мөн хавсралтын 1, 2, 3, 5, 6, 7, 18, 20, 21, 23 дахь заалтыг дор дурдсанаар тус тус өөрчилсүгэй:

(тооцооны нэгжээр)

	Ан амьтны нэр	Олзворын жишиг үнэ	Төлбөр	Хураамж
Нэг. Хөхтөн				
1	Угалз а/ алтайн	24000,0	17000,0	4000,0
	б/говийн	14000,0	10000,0	2000,0
2	Тэх а/алтайн	3000,0	2100,0	500,0
	б/говийн	2600,0	1850,0	450,0
3	Халиун буга	1600,0	1000,0	340,0
5	Цагаан зээр	250,0	160,0	60,0
6	Бор гөрөөс	700,0	500,0	160,0
7	Зэрлэг гахай	320,0	200,0	70,0
Хоёр. Шувуу				
18	Ой хээрийн бусад агнуурын шувуу	20,0	12,0	5,0
20	Нугас	18,0	10,0	6,0
Гурав. Загас				
21	Тул: бариад усанд нь эргүүлж тавих	150,0	100,0	30,0
23	Бусад агнуурын загас	24,0	14,0	6,0

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Д.ОЮУНХОРОЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар
хот

Оюутны спортын IV их наадам зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5, 16.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын оюутны спортын IV их наадмыг 2017 онд орон даяар зохион байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурьт даалгасугай.

2. Оюутны спортын IV их наадмын анхан шатны тэмцээний зардлыг төсөвтөө тусган санхүүжүүлж, зохион байгуулахыг нийслэл, дүүрэг болон холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Оюутны спортын IV их наадмыг зохион байгуулж, дүнг 2018 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурьт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ж.БАТСУУРЬ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 14003